



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 133,400,230.43 (нэг зуун гучин гурван сая дөрвөн зуун мянга хоёр зуун гучин төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Батболд, гүйцэтгэх захирал Д.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000779

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 8-ний өдрийн 438 дугаар
тогтоолын хавсралт

"МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
данснаас хасах хөрөнгийн жагсаалт 8262983

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Сэлбэгээр худалдах, орлогод авах доод үнэ /төгрөг/
1	F-246 маркийн, 38-22 УБ улсын дугаартай, ачааны чирэгч машин	1994/1994	75,069,644.73		500,000.00
2	Huandai county маркийн, 33-67 УБЯ улсын дугаартай, арлын дугаар- KMJHD17FP3C015920	2002/2002	44,214,545.45		500,000.00
3	Мини трактор 40-80 УБ улсын дугаартай арлын дугаар-195-02-TD20	1998/1998	11,116,040.25		500,000.00
4	Электро погрузчик маркийн	1983/1998	1,500,000.00		500,000.00
5	Электро погрузчик маркийн	1983/1999	1,500,000.00		500,000.00
			133,400,230.43		2,500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		133,400,230.43 (нэг зуун гучин гурван сая дөрвөн зуун мянга хоёр зуун гучин төгрөг дөчин гурван мөнгө)		2,500,000.00 (хоёр сая таван зуун)